



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

48090 Мандалговь, Сайнцагаан сум
Утас: 70592439, 70592208, 70593208
E-мэйл: dundgov@audit.gov.mn

2020.07.30 № 123

танай —ны № —т

ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн хурлын 2020 оны сонгуульд оролцох Сайнцагаан сумын Монгол ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох Сайнцагаан сумын Монгол ардын намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт Төрийн аудитын байгууллагад ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” болон холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг шалгуур болгосон.


Дүгнэлт

Сайнцагаан сумын Монгол ардын намын хорооны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцохор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сайнцаган сумын Монгол ардын намын мөрийн хөтөлбөр / ₮.... хуудас/-ийг
хавсаргав.

Хувийг: Сайнцагаан сумын сонгуулийн хороонд
Хавсралт ₮... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР П.ТӨВСАНАА





**2020 ОНЫ АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
САЙНЦАГААН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН
ХӨТӨЛБӨР**

УРИА: САЙНЦАГААНДАА САЙХАН АМЬДРАХЫН ТӨЛӨӨ ХҮЧЭЭ НЭГТГЭЕ.

МАНДАЛГОВЬ ХОТ



Сайнцагаан сумын Монгол Ардын намын хорооны 2020 оны
6 дугаар сарын 23-ны өдрийн 03. тоот тогтоолын хавсралт



САЙНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД МОНГОЛ АРДЫН НАМААС ДЭВШҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

УРИА: САЙНЦАГААНДАА САЙХАН АМЬДРАХЫН ТӨЛӨӨ ХҮЧЭЭ НЭГТГЭЕ.

Эрхэм зорилго: Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн нийгмийн болон үйлдвэрлэлийн дэд бүтэц, амьдрах орчныг сайжруулж, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих замаар дундаж орлоготой өрхийн тоог нэмэгдүүлэн амьдралын чанарыг дээшлүүлнэ.

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2018-2028 дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр”, “Монгол Ардын Намын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр”, “Дундговь аймгийн Монгол Ардын Намын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилсан мөрийн хөтөлбөрийг

- Иргэний хөгжлийн бодлого
- Сайн засаглалын бодлого
- Хөдөө аж ахуйн бодлого
- Эдийн засгийн бодлого
- Шинэ Мандалговь гэсэн 5 үндсэн бүлэг, 28 зорилт, 114 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахаар боловсрууллаа.

НЭГ. ИРГЭНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1 Эрүүл иргэн

1.1.1 “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Хавдрын эсрэг хамтдаа” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.1.2 “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдийн хоолойн архаг /ангина/ өвчнийг эрт илрүүлж эмчлэн, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлэх “Эрүүл ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.1.3 Сайнцагаан сумын эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгүүдийн барилгыг засварлах буюу өргөтгөл хийнэ.

1.1.4 Эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн авто машин, тоног төхөөрөмжийн хангалтыг стандарт түвшинд хүргэж, эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

1.1.5 Малчин бүрийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна.

1.1.6 Эрүүл мэндийн салбарын шилдэг ажилчдыг жил бүр шалгаруулж, эмч эмнэлгийн ажилчдын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

1.1.7 Хотын хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангах ажлыг зохион байгуулна.



1.2 Боловсролтой иргэн

- 1.2.1 Олон улсын жишигт нийцсэн өрөнхий боловсролын сургуулийг шинээр байгуулж, дотоодын их дээд сургуулийн салбар байгуулна.
- 1.2.2 Багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоод сургалт, үйл ажиллагаанд хамруулж “Чадвартай багш-чанартай боловсрол” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.2.3 Цэгц билиг сургуулийн дотуур байртай болгоно.
- 1.2.4 Монгол улсын гавьяат багш Н.Өлзий, З.Цэвээнравдан нарын нэрэмжит матетамик, монгол хэл болон бусад хичээлийн төрөлжсөн олимпиадыг улс болон бүсийн хэмжээнд тогтмол зохион байгуулна.
- 1.2.5 Жил бүр сургууль, цэцэрлэгийн шилдэг багш, ажилчдыг шалгаруулж боловсролын салбарын ажилчдын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцлийг сайжруулна.
- 1.2.6 Боржигон багт есдүгээр цэцэрлэг, хоёрдугаар цэцэрлэгийг буулгаж шинээр барьж ашиглалтанд оруулна.
- 1.2.7 Говийн иргээдүй цогцолбор сургууль, Хүмүүнлэг сургуулиудын барилгыг шинээр барина.

1.3 Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн

- 1.3.1 Мандалговь хотод “Палеонтологи”-ийн музей байгуулна.
- 1.3.2 Ардын урлагийн наадмыг зохион байгуулна.

1.4 Эрүүл, идэвхитэй амьдралтай иргэн

- 1.4.1 Иргэд, олон нийтэд зориулсан усан бассейн, спорт заал бүхий спорт цогцолборыг барьж ашиглалтад оруулна.
- 1.4.2 Иргэд идэвхтэй хөдөлгөөн хийх, явган алхах, дугуй унах зориулалтын зам талбайтай болгоно.
- 1.4.3 Сайнцагаан сумын “Бага олимп” спортын наадмыг 2 жил тутам зохион байгуулна.
- 1.4.4 Улс, бүсийн аварга шалгаруулах үндэсний болон олимпийн төрлийн спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулна.

1.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх оролцоог нэмэгдүүлэх

- 1.5.1 Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийн төвийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулна.
- 1.5.2 Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийн эрх, оролцоог хангаж, нөхөн сэргээх эмчилгээ, сувилгаа хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- 1.5.3 Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдэд хэрэгцээт үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлж нийтийн эзэмшлийн барилга талбайд зориулалтын зам, шатыг суурилуулна.
- 1.5.4 Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид санхүүгийн урамшуулал олгож, тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэнийг ажиллуулаагүй орон тоо тутамд төлөх, төлбөрийн хэмжээ, төрийн байгууллагын удирдах ажилтны хариуцлагыг нэмэгдүүлнэ.

1.6 Ажилтай, орлоготой иргэн

- 1.6.1 Өрхийн бичил бизнесийг дэмжиж, хүүгүй, барьцаагүй санхүүгийн дэмжлэг үзүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

A handwritten signature in black ink, appearing to read "Дундговь Алтан".



1.6.2 Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн гишүүдийг мэргэшил зээмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

1.6.3 Их дээд болон мэргэжлийн сургууль төгссөн залуучуудыг орон нутагтаа ажиллах боломж нөхцлөөр хангана.

1.6.4 Зорилтод бүлгийн иргэдийг хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран ажлын байраар хангана.

1.7 Залуучуудын хөгжлийг дэмжинэ.

1.7.1 Гарааны бизнес эрхлэгч оюутан залуучуудад бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох инкубатор төвийг байгуулна.

1.7.2 Соёл амралтын хүрээлэнг бүрэн засварлаж гэр бүл, хүүхэд, оюутан залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх түүх, соёлын цогцолбор байгуулна.

1.7.3 Оюутан, залуучууд, өсвөр үеийнхнийг гадны сөрөг нөлөө, бусдын дарамт, гэмт хэрэгт өртөх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхээс сэргийлэх, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.7.4 Орчин үеийн стандартад нийцсэн кино театр бүхий хүүхэд, залуучуудын хөгжлийн төвийг байгуулна.

1.8 Ахмадын хөгжлийг дэмжинэ.

1.8.1 Ахмад настны мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлсэн “Ахмадын хөгжлийн ордон”-г барьж дуусган ашиглатад оруулна.

1.8.2 Хөдөлмөрийн чадвартай ахмадуудын орлого нэмэгдүүлэх “Ахмадын хөдөлмөр эрхлэлт” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.8.3 “Ахмад настны хөгжил хамгааллын үндэс”-ний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.9 Нийгмийн хамгааллын бодлогыг оновчтой хэрэгжүүлнэ.

1.9.1 Орлого багатай өрхийн нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэх, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг чанаржуулна.

1.9.2 Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ авах “Цахим карт” бий болгож, урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулна.

1.9.3 Зорилтод бүлгийн өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулна.

1.10. Хүүхэд, гэр бүл эмэгтэйчүүдийн хөгжил

1.10.1 Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж хүүхэд олноор зорчих хэсгийг гарц, хурд сааруулагч, гэрлэн дохио, камертай болгоно.

1.10.2 Хорооллуудын дунд хүүхдийн тоглоомын талбай байгуулж, орчны стандартыг мөрдүүлж хүүхдийн аюулгүй орчинд тоглох нөхцөлийг бүрдүүлнэ.

1.10.3 Эмэгтэйчүүдийн товлолт дархлаажуулалтыг нэвтрүүлж умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх, хөхний эрүүл мэндийг хамгаалах “Энх бүсгүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.10.4 Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэргээс ^Aурьдчилан сэргийлэх, тэднийг хамгаалах “Бусийн хамгаалах төв”-н ^Bуйл ажиллагааг чанаржуулна.

1.10.5 Ясли ажиллуулах эхлэлийг тавина.



ХОЁР. САЙН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

2.1 Мэргэшсэн чадварлаг төрийн алба

2.1.1 Төрийн удирдах болон жинхэнэ, үйлчилгээний албан хаагчдийн ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгон шалгаруулж нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцлийг сайжруулна.

2.1.2 Авилаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх, цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

2.1.3 ЗДТГ болон хотын захиргааны барилга шинээр барих

2.1.4 Хот тохижуулах газрын конторын барилга, засвар үйлчилгээний төвийн барилгыг шинээр барина.

2.2 Шилэн тендерийг зохион байгуулна.

2.2.1 Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа /Тендер/-г нээлттэй ил тод шилэн болгоно.

2.2.2 Төрийн байгууллагуудын "Шилэн данс"-ны хөтлөлтийг сайжруулна.

2.3 Хариуцлагатай уул уурхайг бий болгоно.

2.3.1 Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авч, нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан хамтран ажиллана.

2.3.2 Хариуцлагатай уул уурхай хөгжүүлэх бодлогыг баримтлах, ашигт малтмалын хайгуул, ашиглалт, дэд бүтэц, бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг хийлгэнэ.

2.4 Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

2.4.1 Мандалговь хотыг бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамруулж "Ногоон Мандалговь" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.4.2 Мандалговь хотын ундны усны эх үүсвэрийг шинэчлэн тогтооно.

2.4.3 Шахмал түлшний хэрэглээг нэмэгдүүлж, агаарын бохирдлыг бууруулна.

2.4.4 Мандалговь хотод хог хаягдлыг ангилан ялгах үйлдвэр шинээр барьж, хог хаягдлын менежментийг сайжруулна.

ГУРАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГО

3.1 Малчдын амьжирагааг сайжруулна.

3.1.1 Сайнцагаан омгийн хонины ашиг шим, онцлогийг сурталчилан таниулж "Сайнцагааны мах" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.1.2 Хөдөө аж ахуйн салбарт малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх "Илгээлтийн эзэн-III" аяныг хэрэгжүүлнэ.

3.2 Малаас гарах бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

3.2.1 "Сайнцагаан омог"-ийн хонины цөм сүргийн тоо толгойг зохиомол хээлтүүлгийн аргаар нэмэгдүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна.

3.2.2 "Монгол мал-2" хөтөлбөрийг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулна.

3.3 Мал эмнэлгийн үйлчилгээг чанаржуулна.

3.3.1 Халдварт өвчинтэй тэмцэх, мал сүргийг бүрэн вакцинжуулах ажлыг жил бүр зохион байгуулна.



3.3.2 Баг бурт мал угаалгын ванн барьж, малыг угаалганд бурэн хамруулна.

3.3.3 Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, малын эмч, мал зүйчдийг тэтгэлэгт хөтөлбөрөөр бэлтгэж хөдөө, орон нутагт ажиллуулна.

3.3.4 Мал эмнэлэг, болон хөдөө аж ахуйн тасгийн үйл ажиллагааг дэмжиж машин, техник хэрэгслээр хангана.

3.3.5 Хотын суурьшилын бүс дэх мал, амьтны эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

3.4 Бэлчээрийн менежментийг сайжруулна.

3.4.1 Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж бэлчээрт гүн өрмийн худаг жилд 2-аас доошгүй, энгийн уурхайн худаг жилд 8-аас доошгүйг сэргээн засварлах буюу шинээр гаргана.

3.4.2 Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой байгальд халгүй энгийн механик арга болон микробиологийн аргыг хослуулан тэмцэж бэлчээрийг хамгаална.

3.4.3 Бэлчээрийг зүй зохистой ашиглахад чиглэсэн тэжээлийн ургамал тариалах, бэлчээрийг хашиж хамгаалах санал санаачилгыг дэмжинэ.

3.5 Хүнсний болон газар тариаланг дэмжинэ.

3.5.1 Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний нарийн ногооны нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ.

3.5.2 Усжуулалтыг нэмэгдүүлж чацаргана, төмс, хүнсийн ногоо тариалах хувь хүн, аж ахуйн нэгжийг дэмжинэ.

3.5.3 Газар тариалан эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, стандартын шаардлага хангасан зоорини хангалтыг нэмэгдүүлнэ.

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

4.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжинэ

4.1.1 Мандалговь хотод мах, сүү, хоёрдогч түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулж, жижиг дунд, үйлдвэрлэгчдээд зориулсан бизнес инкубатор төв байгуулна.

4.1.2 Орон нутгийн онцлогтой брэнд хүнсийг дотоод, гадаадын зах зээлд гарах нутгийн иргэдийн өргөн оролцоотой хоршоодыг байгуулахыг дэмжинэ.

4.1.3 Нутгийн онцлогт нийцсэн жижиг, дунд үйлдвэр байгуулна.

4.1.4 Малын гаралтай бүтээгдэхүүнийг малчнаас хэрэглэгчид шууд хургэх нөхцөлийг бүрдүүлнэ.

4.2 Аялал жуулчлалыг дэмжинэ.

4.2.1 Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил, нутгийн онцлогтой бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах, шинээр үйл ажиллагаа эрхлэх санал санаачилгыг дэмжинэ.

4.2.2 Орон нутгийн онцлогийг илтгэсэн бэлэг дурсгал, гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин орлогыг нь нэмэгдүүлэх.

4.3 Төр, хувийн хэвшлийн түншлэл

4.3.1 Дотоод болон гадаадын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

4.3.2 Төр, хувийн хэвшилийн түншлэлийн хүрээнд шинжлэх ухаан, технологи, инновацын тэргүүлэх чиглэлд хөрөнгө оруулалт санхүүжилт татан бичил бизнес эрхлэгч нарыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.



4.3.3 Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг гадаад, дотоодын зах зээлд нэвтрүүлэх үзэсгэлэн худалгааг тогтмол зохион байгуулж, улс, олон улсын чанартай үзэсгэлэн худалдаанд үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулна.

4.3.4 Бизнес эрхлэгчдийн форм, зөвлөгөөнийг 2 жил тутамд зохион байгуулна.

4.4 Үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжируулна.

4.4.1 Зочид буудал, хоол үйлдвэрлэл болон бусад үйлчилгээний чиглэлээр орчин үеийн стандартад нийцсэн үйлчилгээний төв байгуулах санал санаачлагыг бүрэн дэмжинэ.

4.4.2 Олон улсын жишиг стандарт нийцүүлэн сүлжээ рестораныг байгуулах ажлыг эхлүүлнэ.

ТАВ. ШИНЭ МАНДАЛГОВЬ

5.1 Гэрэлтэй Мандалговь

5.1.1 Хотын төвийн хорооллуудын гудамжийг 100 хувь гэрэлтүүлэгтэй болгоно.

5.1.2 Буюннэмэх, Чагдаржав, Наранцацралт, их, бага тойруугийн өргөн чөлөөнүүдэд "Гэрэлт гудамж" төслийг үе шаттай хэрэгжүүлнэ.

5.1.3 Албан байгууллага, аж ахуйн нэгж, нийтийн орон сууцнуудын гадна гэрэлтүүлэг, гоёлын гэрэл, чимэглэлийг нэмэгдүүлнэ.

5.2 Ногоон Мандалговь

5.2.1 Өрх бүр мод тарих хөдөлгөөнийг өрнүүлж, хорооллын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.

5.2.2 Аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээний байгууллагуудын орчныг тохижилтыг сайжруулж, зүлэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

5.2.3 Ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэнгийн тоог нэмэгдүүлнэ.

5.2.4 Орчин үеийн тоноглол бүхий мод үржүүлгийн газар байгуулж, хотын ногоон байгууламжийн хэмжээг 2-3 дахин нэмэгдүүлнэ.

5.2.5 Хотын ногоон байгууламжийн усалгааны системийг бүрэн шийдвэрлэнэ.

5.3 Цэмцгэр Мандалговь

5.3.1 Гэр хорооллын дэд бүтцийг сайжруулан, иргэдийн ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бий болгох "Хашаандаа сайхан амьдаръя" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

5.3.2 Гэр хорооллын инженерийн дэд бүтцийг нэмэгдүүлнэ.

5.3.3 "Шинэ гудамж", "Шинэ хороолол" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

5.3.4 Хот тохижуулах газрын бүтэц, орон тоо, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлж, хог тээвэрлэлтийн үйл ажиллагааг сайжруулуулна.

5.3.5 Мандалговь хотын хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор "Эко жорлон"-гийн хэрэглээг нэмэгдүүлж, нүхэн жорлонг 50 хувиар бууруулна.

5.3.6 Нийтийн эзэмшлийн зам, талбай, гэрэлтүүлгийн арчилгаа, засвар үйлчилгээг бүрэн шийдвэрлэнэ.

5.4 Цахим Мандалговь

5.4.1 Төрийн байгууллагад байгаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг бүрэн халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг "Нэг иргэн-нэг бүртгэл" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.



5.4.2 Иргэд, олон нийттэй харилцах мэдээллийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, төр иргэний эргэх холбоог сайжруулна.

5.4.3 Төрийн цахим үйлчилгээний "Хур" системийг нэвтрүүлнэ.

5.4.4 Хотын хяналт, удирдлагын нэгдсэн төвийг байгуулна.

5.5 Бүтээн байгуулалт

5.5.1 3000м3 хүчин чадалтай биологийн цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулна.

5.5.2 Мандалговь хотын 8.1 км бохир ус, 3.6 км цэвэр усны шугам сүлжээний ажлыг шинээр гүйцэтгэнэ.

5.5.3 Мандалговь хот доторх хатуу хучилтай замыг засварлаж, шинээр 14 чиглэлд 8.3 км засмал зам тавина.

5.5.4 Хотын төвийн орон сууцнуудын дээвэр болон гадна фасадыг шинэчилж, орчны тохижилтыг цогцоор нь бий болгоно.

5.5.5 Мандалговь хотод дулааны станц барьж ашиглалтанд оруулна.

5.5.6 Дулааны шугамын 22.2 км урт хоёрдугаар хэлхээний өргөтгөлийн ажлыг хийж, гэр хорооллын өрхүүдийг холбох нөхцөлийг бүрдүүлнэ.

5.5.7 Үерийн далангийн ажлыг үргэлжлүүлж ус зайлцуулах 6.4 км суваг хоолойн ажлыг хийж дуусгана.

5.5.8 Арвайхээр-Мандалговь-Чойр чиглэлийн авто замыг шинээр барихад хот болонsumaas шалтгаалах асуудлуудыг шийдвэрлэнэ.

5.5.9 Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замыг шинэчлэн засварлах ажлыг эхлүүлэхэд бүх талаар дэмжин ажиллана.

5.5.10 Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийг хэрэгжүүлж 300 өрхийг тохилог амины орон сууцны хорооллыг байгуулна.

5.5.11 Зөвшөөрөл олгогдсон барилгажилт төслийн хүрээнд 500 айлын орон сууцны хорооллыг бий болгоно.

5.5.12 Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгуудыг буулгаж шинээр 100 айлын орон сууцыг барина.

5.5.13 Төр, орон нутаг, хувийн хэвшлийн оролцоотой 100 айлын "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

5.5.14 Боржигон багт халуун усны газар бүхий нийтийн ахуйн үйлчилгээний төвийг байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.



Б.Б.